

## **2018 ОНЫ 2 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 9 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

### **Нэг. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2018 оны 2 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн амбулаторийн үзлэг хүлээгдэлтэй ажилласан бол ЭХЭМҮТ-ийн амбулаторийн кабинетүүдэд хүлээгдэл бүртгэгдээгүй, тусламж үйлчилгээг өдөрт нь үзүүлсэн байна.


УНТЭ-ийн амбулаторийн 7 кабинетэд нийт 31 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 8 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнээс: Зүрх судасны кабинетэд 3 хүртэл хоног 17, уушигны кабинетэд 1, мэс заслын кабинетэд 3, нүд судлал 2, чих хамар хоолой 1, мэдрэл судлалын кабинетэд 1, хоол боловсруулах эрхтэн судлал 6 үйлчлүүлэгч тус бүр 2 хоногийн хугацаатай хүлээгдэлд бүртгэгджээ.

УХТЭ-ийн амбулаторийн 11 кабинетэд нийт 65 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 58 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд: бөөр судлалын кабинетэд 7, зүрх судасны кабинетэд 6 үйлчлүүлэгч, уушиг судлалын кабинетэд 7 үйлчлүүлэгч, мэдрэл судлал 6, мэс заслын кабинет 5, хоол боловсруулах эрхтэн судлал 6 үйлчлүүлэгч тус бүр 1-3 хоног, эмэгтэйчүүдийн кабинетэд 8 үйлчлүүлэгч, булчирхай судлал 6 үйлчлүүлэгч, урологийн кабинет 6 үйлчлүүлэгч, чих хамар хоолой 5 үйлчлүүлэгч тус бүр 2 хоног, нүдний кабинет 3 үйлчлүүлэгч тус бүр 1 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-ийн зүрх судасны кабинетэд 1-2 хоногийн хугацаанд 42 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 8 кабинетэд нийт 117 үйлчлүүлэгчийн хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс элэг цөс нойр булчирхайн кабинет 26 үйлчлүүлэгч, хими эмчилгээний кабинет 9 үйлчлүүлэгч тус бүр 1-ээс 7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд, цээжний хөндийн мэс засалд 14 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетэд 34 үйлчлүүлэгч тус бүр 1-6 хоногийн хугацаанд хүлээж байна. Ерөнхий мэс заслын кабинет 18 үйлчлүүлэгч, толгой хүзүүний мэс заслын кабинетэд 7, туяа эмчилгээний кабинетэд 5 үйлчлүүлэгч, хөнгөвчлөх эмчилгээнд 4, үйлчлүүлэгч тус бүр 2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

УНТЭ, УХТЭ-ийн 2-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



**Хоёр. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:**

2018 оны 2 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн 1-р сарын мэдээнд бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээ хийлгэхээр 31 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээгдэж байсан бол 2 сарын мэдээнд хүлээгдэл байхгүй байна. Рентген 35 үйлчлүүлэгч 1-6х хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 21 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хэвлийн эхо 78 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 20 үйлчлүүлэгчээр цөөн байна. Зүрхний цахилгаан бичлэг 3 үйлчлүүлэгч 1 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Тархины цахилгаан бичлэг хийлгэхээр 1 үйлчлүүлэгч 1 хоног хүлээж үйлчлүүлжээ. Радиоимунологийн шинжилгээнд 70 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.


УХТЭ-т рентген зураг авахуулахаар 61, хэвлийн эхо 3, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 18, дурангийн шинжилгээнд 4, үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоног, нүдний уг харах 2, MRI/КТГ хийлгэхээр 2 үйлчлүүлэгч 1-2 хоног, холтер хийлгэхээр 1 үйлчлүүлэгч 1 хоног доплерографийн шинжилгээнд 21 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т хэвлийн эход харуулахаар 61, рентген зураг авахуулахаар 38, доплерографийн шинжилгээнд 13, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 40, тархины цахилгаан бичлэг хийлгэх 7, зүрхний эход харуулахаар 5 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.


ХСҮТ-д бүдүүн шулуун гэдэсний дуран 2, хэвлийн эход харуулахаар 67, рентген харалт 46, уушигний дуран 1, ходоодны дуран 30 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 173 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 94 өдөртөө, 36 үйлчлүүлэгч 1 хоног, 8 үйлчлүүлэгч 2 хоног, 20 үйлчлүүлэгч 3-6 хоног, 15 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Төв эмнэлгүүдийн оношлогооны кабинетийн 2-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний 1, 2-р сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



**Гурав. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**


2018 оны 2 дугаар сард УХТЭ, УГТЭ лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т цусны ерөнхий шинжилгээ 52, шээсний ерөнхий шинжилгээ 44, биохимийн шинжилгээ 390 үйлчлүүлэгч 1 хоног хүлээгдэлтэй, 21 үйлчлүүлэгч 2 хоногийн хүлээгдэлтэй байна. Бактериологийн шинжилгээ 31, иммунологийн шинжилгээ 3, коагулограммын шинжилгээ 10 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т цусны ерөнхий шинжилгээ 89, шээсний ерөнхий шинжилгээ 13, биохимийн шинжилгээ 114 үйлчлүүлэгч, иммунологийн шинжилгээ 20, коагулограммын шинжилгээ 38, серологи 10 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д цусны ерөнхий шинжилгээ 120, шээсний ерөнхий шинжилгээ 48, биохимийн шинжилгээ 224 үйлчлүүлэгч, бактериологи шинжилгээ 9, иммунологийн шинжилгээ 113, коагулограммын шинжилгээ 34, үйлчлүүлэгч 1-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн лабораторийн кабинетийн 2-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



**Дөрөв. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

2018 оны 2 дүгээр сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, бүртгэн мэдээлсэн.

УНТЭ-ийн зүрх судасны тасагт 1, дотоод шүүрлийн тасагт 1 үйлчлүүлэгч тус бүр 1-3 хоног хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн.


УХТЭ-т 2-р сард 148 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр 1-14 хүртэл хоногийн хугацаанд хүлээсэн байна. Энэ нь өмнөх сарынхаас 60 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд: Бөөр судлалын тасагт 10 үйлчлүүлэгч 1-6 хоног, зүрх судасны тасаг 16, уушигны тасаг 5, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 16 үйлчлүүлэгч, мэс засал 77 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоног, мэдрэлийн тасагт 24 үйлчлүүлэгч 3-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т 2-р сард нийт 92 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарынхаас 28 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнээс: мэдрэлийн мэс засалд 29 үйлчлүүлэгч 1-30 хоног, зүрх судасны тасагт 10, бөөр судлалын тасагт 3, мэдрэлийн тасаг 13 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хүртэл хоног, чих хамар хоолойн тасагт 30, хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг 7 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

ЭХЭМҮТ-ийн эрсдэлтэй жирэмсэн судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 6 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 35, 3-6 хоног 43, 7-14 хоног 33, 15-30 хоногийн хугацаанд 23, нийт 134 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өмнөх сарынхаас 67 үйлчлүүлэгчээр буурсан байна.

Сүүлийн 6 сарын хугацаанд СЭМҮТ-ийн неврозын тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/



**Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харъяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан, Налайх дүүргийн ЭМТ-ийн мэдрэл, ХУД-ийн ЭМТ-ийн дотор, БЗД-ийн НЭ-ийн доторын тасаг, Наркологийн төв тус бүр 15-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.


Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 2-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХДЭМТ	ХУДЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Нарколог ийн эмнэлэг
			2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	37	11	0	7	17	16	0	0	0	0	0
		1-3 хоног		6		2		1					
		3-6 хоног	9	4		3	1	13					
		7-14хоног	16	1		2	16	2					
		15-30 хоног	12										
		1 сараас дээш											
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	34	48	118	28	0	30	6	0	0	0	0
		1-3 хоног		14	10	9		15	3				
		3-6 хоног		14	21	9		10	3				
		7-14хоног	34	20	31	5		5					
		15-30 хоног			56	5							
		1 сараас дээш											
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	39	0	0	0	0	15	0	0	0	0	0
		1-3 хоног	13					8					
		3-6 хоног	26					7					
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	11	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног				3							
		3-6 хоног											
		7-14хоног				8							
		15-30 хоног											
		1 сараас дээш											


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХДЭМТ	ХУДЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн эмнэлэг	
			2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар	2 сар
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
		1-3 хоног												
		3-6 хоног												
		7-14хоног												
		15-30 хоног												
		1 сараас дээш												
7	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	68	
		1-3 хоног												23
		3-6 хоног												34
		7-14хоног												9
		15-30 хоног												2
		1 сараас дээш												

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2 дүгээр сард 23553 дуудлага бүртгэгдсэний 33.7%-ийг 0-20 минутад, 32.3%-ийг 21-40 минутад, 18,3%-ийг 41-60 минутад, 15.7%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 12, 1, 2-р сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



Нийслэлийн түргэн тусламжийн төвд  
сүүлийн 6 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА